



ИНД - 119

Иргэний Нисэхийн Дүрэм

Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-119 нь арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын иргэний гэрчилгээжүүлэлтийн шаардлага болон тухайн гэрчилгээний хадгалалтын үйл ажиллагааны шаардлагыг тогтооно. Арилжааны нислэгийн үйл ажиллагаанд Агаарын тээврийн үйл ажиллагаа болон Тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагаа багтана.

ИНД-119 нь гэрчилгээжүүлэлтийн дараах хоёр түвшнийг тогтооно:

- шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ - том, дунд болон жижиг агаарын хөлгөөр арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөг;
- ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ - нисдэг тэрэг болон 9, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудалтай нисэх онгоцоор арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөг.

ИНД-119 нь агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлтийн ИCAO-гийн стандарт болон байгууллагын гэрчилгээжүүлэлттэй холбоотой дүрмийн бүтцийг дагаж мөрддөг.

Тухайн бүтэц нь арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлтийн (үйл ажиллагаа эхлүүлэх стандарт), үйл ажиллагааны (үйл ажиллагааг үргэлжлүүлэх) болон аюулгүй байдлын аудитын (хяналт) тусгай шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-119-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-119, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчин төгөлдөр огноо**

Анхны боловсруулалт	2001 оны 03 сарын 16
Нэмэлт, өөрчлөлт 1	2002 оны 09 сарын 17
Нэмэлт, өөрчлөлт 2	2005 оны 09 сарын 14
Нэмэлт, өөрчлөлт 3	2007 оны 05 сарын 04
Нэмэлт, өөрчлөлт 4	2008 оны 09 сарын 11
Нэмэлт, өөрчлөлт 5	2010 оны 04 сарын 16
Нэмэлт, өөрчлөлт 6 (Шинэчлэлт)	2019 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-119-ийн шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 119-ийн 2017 оны 03 сарын 10-ны А.16-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл.....	1
119.1. Зорилго.....	1
119.3. Нэр томъёо болон товчлол	1
119.5. Гэрчилгээний шаардлага	1
119.7. Нөөц	1
119.9. Гэрчилгээ эзэмших хүсэлт	1
119.11. Гэрчилгээ олгох	2
119.13. Гэрчилгээ эзэмшигчийн эрх	2
119.15. Үйл ажиллагааны тодорхойлолт	3
119.17. Гэрчилгээний хугацаа.....	3
119.19. Үйл ажиллагааг зогсоох мэдэгдэл	3
119.21. Гэрчилгээ сунгах.....	4
В Бүлэг - Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага ...	4
119.51. Ажилтанд тавих шаардлага	4
119.53. Ажилтны ур чадварын шаардлага.....	5
119.55. Байгууламжид тавих шаардлага	5
119.57. Бататгах нислэг, эсхүл тест	6
119.59. Нөөц	6
119.61. Техник үйлчилгээний журам	6
119.63. Техник үйлчилгээний хөтөлбөр	6
119.65. Баримт бичиг	7
119.67. Ажилтнуудын бүртгэл.....	8
119.69. Байгууламжийн бүртгэл	8
119.71. Нислэгийн зөвшөөрөл болон хяналт.....	8
119.73. Нислэг дагах хяналтын үйлчилгээ.....	8
119.75. Агаарын тээвэрлэгчийн Аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр.....	9
119.77. Үйл ажиллагааны журам тогтоох.....	9
119.79. Аюулгүй байдлын удирдлага	9
119.81. Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий заавар.....	9
С Бүлэг - Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага	11
119.101. Ажилтанд тавих шаардлага	11
119.103. Ажилтны ур чадварын шаардлага.....	12
119.105. Байгууламжид тавих шаардлага	12
119.107. Бататгах нислэг, эсхүл тест	13
119.109. Техник үйлчилгээний журам	13
119.111. Техник үйлчилгээний хөтөлбөр	13
119.113. Баримт бичиг	14
119.115. Ажилтны бүртгэл	14
119.117. Байгууламжийн бүртгэл	15
119.119. Нислэгийн зөвшөөрөл болон хяналт.....	15
119.121. Нислэг дагах хяналтын үйлчилгээ.....	15
119.123. Үйл ажиллагааны журмыг тогтоох.....	16

119.124.	Аюулгүй байдлын удирдлага	16
119.125.	Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий заавар	16
D Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага.....		18
119.151.	Байнгын хэрэгжилт	18
119.153.	Нислэгийн үйл ажиллагааны шаардлага	18
119.155.	Нисэх багийн гишүүний мэргэшил.....	19
119.157.	Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн чартер, давхар-түрээс болон түрээс	19
119.159.	Монгол Улсын бүртгэлгүй агаарын хөлөг ашиглах	19
119.161.	Бизнесийн, эсхүл худалдааны нэр	20
119.163.	Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн хязгаарлалт	20
119.165.	Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт	20
119.167.	Техник үйлчилгээний хөтөлбөрт өөрчлөлт оруулах.....	21
119.201.	ИНД-121, эсхүл ИНД-125-ын үйл ажиллагаа эрхэлдэг шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт	21
119.203.	ИНД-135-ын үйл ажиллагаа эрхэлж байгаа шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт	22
119.205.	Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн дотоод чанар баталгаажуулалтын шилжилт	23
119.207.	Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт	25
119.209.	Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч, эсхүл хүсэлт гаргагчийн байгууллагын удирдлагын тогтолцооны шилжилт.....	26
Хавсралт А - Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн удирдах ажилтны мэргэшил болон туршлага.....		28
A.1.	Нислэг хариуцсан удирдах ажилтан	28
A.2.	Багийн гишүүдийн сургалт болон ур чадварын үнэлгээ хариуцсан удирдах ажилтан	29
A.3.	Техник үйлчилгээний удирдлага болон төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан	30
A.4.	Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан.	32
A.5.	Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан	32
Хавсралт В - Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн удирдах ажилтны мэргэшил болон туршлага		33
V.1.	Нислэг хариуцсан удирдах ажилтан	33
V.2.	Багийн гишүүдийн сургалт болон ур чадварын үнэлгээ хариуцсан удирдах ажилтан	34
V.3.	Техник үйлчилгээний удирдлага болон төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан	34
V.4.	Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан.	35
V.5.	Байгууллагын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан	36

ИНД-119 Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт

А Бүлэг - Ерөнхий зүйл

119.1. Зорилго

Энэ Дүрэм нь ИНД-121, ИНД-125 болон ИНД-135-ын дагуу арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа Монгол улсын иргэний гэрчилгээжүүлэлтийн шаардлага болон тухайн гэрчилгээний хадгалалтын үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.

119.3. Нэр томьёо болон товчлол

Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.

119.5. Гэрчилгээний шаардлага

(а) Арилжааны нислэгийн үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж байгаа этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг (цаашид АТ-ийн гэрчилгээ гэх) эзэмших ёстой ба тухайн гэрчилгээний нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.

(b) Аливаа этгээд нь хууль болон энэ Дүрмийн дагуу олгосон АТ-ийн гэрчилгээний эрхийн хүрээ болон хязгаарлалтад заагаагүй арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэхгүй байх үүрэгтэй.

(c) Энэ зүйлийн (а)-ийн зорилгоор, хэрэв тухайн этгээд нь дараах хоёр, эсхүл түүнээс дээш ажил үүрэг хариуцдаг бол тухайн этгээдийг арилжааны нислэгийн үйл ажиллагааг бүхэлд нь хариуцдаг гэж үзнэ:

- (1) үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэж болох эсэхийг тодорхойлдог байх;
- (2) тухайн нислэгийн үйл ажиллагаанд багийн гишүүдийг томилдог байх;
- (3) нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх багийн гишүүдийг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр авч ажиллуулдаг байх;
- (4) аюулгүй байдлын үндэслэлээр хөлгийн даргын гаргадаг шийдвэрээс бусад, нислэгийн үйл ажиллагааг өөрчлөх шийдвэр гаргадаг байх.

119.7. Нөөц

119.9. Гэрчилгээ эзэмших хүсэлт

АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг шаардсан САА 24119/01 маягтыг бөглөж, Дарга илүү богино хугацааг хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд, төлөвлөсөн үйл ажиллагааг эхлэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлнэ:

- (1) хүсэлт гаргагчийн Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх нэр, хаяг;
- (2) 119.15(b)-д шаардсан, Үйл ажиллагааны тодорхойлолтод шаардлагатай дэлгэрэнгүй мэдээлэл;
- (3) дараах Ерөнхий заавар:

- (i) шугамын АТ-ийн гэрчилгээний хувьд, 119.81-д шаардсан; эсхүл
- (ii) ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээний хувьд, 119.125-д шаардсан;
- (4) тухайн хүсэлт гаргагчтай холбоотой маягтад заасан, Даргын шаардаж болох бусад мэдээлэл.

119.11. Гэрчилгээ олгох

(a) Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь хуулийн дагуу шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших эрхтэй:

- (1) хүсэлт гаргагч нь В Бүлгийн холбогдох шаардлагыг хангасан байх;
- (2) хүсэлт гаргагч нь хувь хүн бол, хүсэлт гаргагч болон 119.51(a)(1), (2)-т шаардсан түүний удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн байх;
- (3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

(b) Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь хуулийн дагуу ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших эрхтэй:

- (1) хүсэлт гаргагч нь С Бүлгийн холбогдох шаардлага хангасан байх;
- (2) хүсэлт гаргагч нь хувь хүн бол, хүсэлт гаргагч болон 119.101(a)(1), (2)-т шаардсан удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн байх;
- (3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

119.13. Гэрчилгээ эзэмшигчийн эрх

(a) АТ-ийн гэрчилгээнд, тухайн гэрчилгээ эзэмшигчийн гүйцэтгэхээр зөвшөөрөгдсөн эрхийг заана.

(b) АТ-ийн гэрчилгээ нь, тухайн гэрчилгээ эзэмшигчид дараах үйл ажиллагаа гүйцэтгэх эрх олгоно:

- (1) гэрчилгээ эзэмшигчийн АТ-ийн гэрчилгээнд заасан арилжааны нислэгийн үйл ажиллагаа;
- (2) ашигладаг, эсхүл ашиглахаар төлөвлөсөн агаарын хөлөгт хамаарах газрын бэлтгэл сургалт болон нислэгийн сургалт хийх;
- (3) нисэх багийн гишүүдийн ур чадварыг тодорхойлох тест, эсхүл шалгалтын нислэг хийх;
- (4) гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан үйлчилгээ үзүүлдэг, эсхүл үйл ажиллагаа гүйцэтгэдэг бусад этгээдийн ур чадварыг тодорхойлох тест, эсхүл шалгалт авах.

119.15. Үйл ажиллагааны тодорхойлолт

(a) Хууль болон энэ Дүрмийн дагуу олгосон АТ-ийн гэрчилгээнд энэ зүйлийн (b)-д заасан Үйл ажиллагааны тодорхойлолтыг хавсаргасан байх ёстой.

(b) Үйл ажиллагааны тодорхойлолт нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:

- (1) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны үндсэн баазын байрлалын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (2) гэрчилгээ эзэмшигчийн Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх хаяг;
- (3) гэрчилгээ эзэмшигч үйл ажиллагаа эрхэлж болох бизнесийн бусад нэр;
- (4) ашиглахыг зөвшөөрсөн агаарын хөлгийн маяг, серийн болон бүртгэлийн дугаар;
- (5) зөвшөөрөгдсөн арилжааны нислэгийн үйл ажиллагааны төрлийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (6) нислэгийн зам болон үйл ажиллагааны бүсийн зөвшөөрөл болон хязгаарлалт;
- (7) энэ Дүрэм, эсхүл бусад ИНД-ийн шаардлагаас чөлөөлсөн мэдээлэл;
- (8) тодорхой нөхцөл байдлыг зохицуулах зорилгоор Даргын шаардлагатай гэж үзсэн бусад зүйл.

(c) Дарга, SEIFR-аар зорчигч тээвэрлэх үйл ажиллагааны зөвшөөрөл олгохдоо гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолтод зөвшөөрлийн хугацааг АТ-ийн гэрчилгээний хүчинтэй хугацаанаас богино хугацаагаар тогтоож болно.

(d) Дарга, EDTO нислэгийн зөвшөөрөл олгохдоо гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны тодорхойлолтод дараах мэдээллийг заах үүрэгтэй:

- (1) EDTO нислэгт зөвшөөрөгдсөн нисэх онгоцны бүртгэлийн дугаар;
- (2) энэ хэсгийн (1)-д заасан, EDTO нислэгт зөвшөөрөгдсөн нисэх онгоцны максимум даялалтын хугацаа;
- (3) EDTO нислэгт зөвшөөрөгдсөн EDTO нислэгийн бэлтгэл аэродром.

119.17. Гэрчилгээний хугацаа

(a) АТ-ийн гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.

(b) АТ-ийн гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл Дарга гэрчилгээг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна.

(c) Хугацаа нь дууссан, эсхүл хүчингүй болсон АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээг Даргад нэн даруй хураалгана.

(d) Түдгэлзүүлсэн АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь холбогдох баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр гэрчилгээг Даргад хүргүүлнэ.

119.19. Үйл ажиллагааг зогсоох мэдэгдэл

Арилжааны нислэгийн үйл ажиллагаагаа зогсоосон АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь зогсоосон өдрөөс хойш 30 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэнэ.

119.21. Гэрчилгээ сунгах

- (a) АТ-ийн гэрчилгээ сунгуулах хүсэлтийг САА 24119/01 маягтын дагуу гаргах ёстой.
- (b) Хүсэлтийг тухайн гэрчилгээнд заасан сунгах хугацаанаас өмнө, эсхүл, хэрэв сунгах хугацаа заагаагүй бол гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.

В Бүлэг - Шугамын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага**119.51. Ажилтанд тавих шаардлага**

- (a) Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах этгээдийг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:

- (1) Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон дараах үүрэгтэй удирдах ажилтан:

- (i) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа бүх үйл ажиллагааг санхүүжүүлэх ба энэ Дүрэмд заасан шаардлага болон стандартын дагуу гүйцэтгэж чадахаа хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах;
- (ii) хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах;

- (2) дараах удирдах ажилтнууд:

- (i) хүсэлт гаргагчийн байгууллага нь Ерөнхий заавраа дагаж мөрдөж байгааг бататгах хариуцлага хүлээх;
- (ii) энэ зүйлийн (b)(1)-д заасан ажил үүрэгт хариуцлага хүлээх;
- (iii) Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх;

- (3) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах болон гэрчилгээжүүлэх хангалттай тооны ажилтан.

- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан удирдах ажилтнууд нь дараах үүрэгтэй:

- (1) Дарга өөр хэлбэрээр хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд, хүсэлт гаргагчийн байгууллагын хэмжээ, төлөвлөж байгаа үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалан дараах нэгээс ихгүй албан тушаалд хариуцлага хүлээх:

- (i) нислэгийн үйл ажиллагаа болон газрын дэмжих үйл ажиллагааг багтаасан нислэг хариуцсан удирдах ажилтан;
- (ii) багийн гишүүдийн сургалт болон ур чадварын үнэлгээ хариуцсан удирдах ажилтан;
- (iii) техник үйлчилгээний удирдлага болон төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан;
- (iv) 119.79-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан;
- (v) агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалт хариуцсан удирдах ажилтан, хэрэв 119.75-д агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг шаардсан бол;

- (vi) хэрэг явдлыг ИНД-12-ын дагуу шинжлэн шалгах удирдах ажилтан;
 - (2) тэдний хариуцлага хүлээх ажил үүрэгт хамаарах, Хавсралт А-д заасан минимум мэргэшил болон туршлагыг эзэмшсэн байх.
- (c) Энэ зүйлийн (b)(1)(ii)-ыг үл харгалзан, хэрэв хүсэлт гаргагчийн байгууллагын бүтцэд тохирох бол ур чадварын үнэлгээ хийх удирдах ажилтны үүрэг хариуцлагыг, энэ зүйлийн (b)(1)(i)-ийн дагуу нислэг хариуцсан удирдах ажилтанд нэгтгэж болно.
- (d) Эрх шилжүүлэх нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ба тухайн ажлыг хариуцсан удирдах ажилтанд хариуцлага нь хадгалагдсан хэвээр байх тохиолдолд, энэ зүйлийн (b)(1)-д заасан ажил үүргийг өөр ажилтанд шилжүүлж болно.

119.53. Ажилтны ур чадварын шаардлага

(a) Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:

- (1) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан арилжааны нислэгийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах, эсхүл гэрчилгээжүүлэх эрх бүхий ажилтны ур чадварт суурь үнэлгээ хийх болон түүнийг хадгалах;
- (2) ажилтнуудад тэдний эрхийн хүрээг нотолсон, бичгээр үйлдсэн баримт олгодог болохыг бататгах.

(b) Хүсэлт гаргагч нь, ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн бөгөөд энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу хүсэлт гаргагчийн ажилтны ур чадварыг хадгалах зорилгоор үнэлгээ хийх, эсхүл сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэх эрх зохих ёсоор олгогдсон байгууллагатай гэрээ байгуулж болно.

(c) Энэ зүйлийн (b)-гийн дагуу бусад байгууллагатай гэрээ байгуулсан хүсэлт гаргагч нь дараах дэлгэрэнгүй мэдээллийг Ерөнхий заавартаа оруулсан байна:

- (1) тухайн байгууллагад шилжүүлэх ажил үүрэг;
- (2) тухайн байгууллагын зохион байгуулах сургалт, эсхүл авах шалгалтын цар хүрээ;
- (3) сургалт зохион байгуулах болон шалгалт авахтай холбоотой байгууллагын эрх.

119.55. Байгууламжид тавих шаардлага

(a) Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц, дараах байгууламжтай байна:

- (1) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан үйл ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангах;
- (2) шаардлагатай тохиолдолд, дараах байгууламж болон төхөөрөмжийг багтаасан:
 - (i) захиргааны болон ажлын байр, засвар үйлчилгээний ажлын байр, ангар болон бусад барилга байгууламж;
 - (ii) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай төхөөрөмж, багаж хэрэгсэл, материал, сургалтын туслах хэрэгсэл, өгөгдөл болон баримт бичиг.

- (b) Хүсэлт гаргагч нь дараах ажлын орчин нөхцөлийг бүрдүүлсэн болохыг бататгана:
- (1) гүйцэтгэх ажилд тохирсон;
 - (2) шаардлагатай тохиолдолд, цаг агаарын нөхцөлөөс хамгаалагдсан.

119.57. Бататгах нислэг, эсхүл тест

- (a) Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших, эсхүл гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт гаргагч нь, хэрэв Дарга шаардсан бол холбогдох шаардлагыг хангаж чадахаа батлах зорилгоор бататгах нислэг, эсхүл тест хийнэ.
- (b) Тухайн нислэг, эсхүл тестийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр гүйцэтгэсэн байна.

119.59. Нөөц

119.61. Техник үйлчилгээний журам

- (a) Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах агаарын хөлөг, төхөөрөмжийн НТЧ-ын хадгалалтыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:
- (1) тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлөг;
 - (2) тухайн агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл бэхэлсэн төхөөрөмж.
- (b) Өөрийн агаарын хөлгийн техник үйлчилгээг бусад этгээдээр гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, 119.81-д шаардсан Ерөнхий зааварт дараах дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан байх үүрэгтэй:
- (1) бусад этгээдэд шилжүүлэх ажил үүрэг;
 - (2) бусад этгээдийн гүйцэтгэх техник үйлчилгээний цар хүрээ;
 - (3) гүйцэтгэх ажил үүрэг, техник үйлчилгээтэй холбоотой бусад этгээдийн эрх.

119.63. Техник үйлчилгээний хөтөлбөр

- (a) Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлөг бүрд зориулсан техник үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөр нь дараах мэдээллийг багтаасан байх ёстой:
- (1) тухайн хөтөлбөрт хамрагдах агаарын хөлгийн маяг, бүртгэлийн болон серийн дугаар;
 - (2) агаарын хөлгийн хүчилсэн бүтэц, агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнс, даах сэнс, хэрэгсэл, ослын төхөөрөмжийн шаардлагатай үзлэг шалгалт, тест болон дараах эд анги, түүний байрлалын дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээг гүйцэтгэхэд зориулсан ИНД-91-ийн G Бүлэг болон үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарьт заасан минимум шаардлагатай дүйцэх зааварчилгаа, журам:
 - (i) үзлэг шалгалт хийсэн байх шаардлагатай;

- (ii) хэрэв техник үйлчилгээг зохих ёсоор гүйцэтгээгүй бол, эсхүл хэрэв зориулалтын бус материал, эсхүл эд анги ашигласан бол тухайн агаарын хөлгийн аюулгүй үйл ажиллагаанд аюул учруулах татгалзал, доголдол, эсхүл гэмтэлд хүргэж болох;
- (3) ашиглалтын цаг, цикл, хуанлийн хугацаа болон үйл ажиллагааны системийн тоо, эсхүл тэдгээрийн аливаа хослолоор илэрхийлэгдэх, энэ зүйлийн (b)(2)-ын дагуу техник үйлчилгээ гүйцэтгэх хуваарь;
- (4) агаарын хөлгийг техник үйлчилгээний хөтөлбөрт шилжүүлэх журам;
- (5) хэрэв тухайн хөтөлбөр нь нөхцөлөөр хянах техник үйлчилгээ (condition monitored maintenance), эсхүл үзүүлэлт болон ашиглалтын мониторингийн (health and usage monitoring) системээс гарсан мэдээллийг ашигладаг бол техник үйлчилгээний чиг хандлагад (трэнд) дүн шинжилгээ хийх журам;
- (6) техник үйлчилгээний хөтөлбөрт шаардсан үзлэг шалгалтыг хийдэг болохыг бататгах журам;
- (7) бүртгэл хөтлөх жишээг багтаасан, гэмтлийг бүртгэх журам;
- (8) гэмтлийг засах, эсхүл түүнийг хойшлуулах журам;
- (9) ашиглалтын туршлагад үндэслэн үзлэг шалгалтын үечлэлийг өөрчлөх журам;
- (10) ИНД-91.623-ын дагуу техник үйлчилгээний бүртгэлийг хадгалах журам.

119.65. Баримт бичиг

(a) Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь өөрийн үйл ажиллагаа, аюулгүй байдал болон техник үйлчилгээний өгөгдлийг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах, түгээх журмыг тогтоосон байна.

(b) Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-91, ИНД-108, ИНД-121, ИНД-125 болон ИНД-135-ыг багтаасан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй, холбогдох бусад ИНД-ээр шаардсан баримт бичгийн хяналтын журмыг тогтоосон байна.

(c) Энэ зүйлийн (a), (b)-д шаардсан журам нь дараах шаардлагыг бататгана:

- (1) бүх баримт бичгийг боловсруулж гаргахаас өмнө холбогдох этгээд хянаж, зөвшөөрдөг байх;
- (2) бүх холбогдох баримт бичгийн хүчинтэй хувийг, шаардлагатай бүх байрлалд ажилтан авч ашиглахад хэвлэмэл, цахим, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр бэлэн байлгах;
- (3) хүчингүй болсон бүх баримт бичгийг боловсруулж гаргасан, эсхүл ашиглаж байгаа цэг бүрээс нэн даруй хураан авдаг байх;
- (4) тухайн баримт бичгийн өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж, зөвшөөрдөг байх;
- (5) өөрчлөгдөж хүчингүй болсон материалыг ашиглахаас сэргийлж, баримт бичгийн хуудас бүрийн хүчинтэй хувилбарыг таньж тогтоож болдог байх.

119.67. Ажилтнуудын бүртгэл

Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) дараах бүртгэлийг үнэн зөв хөтөлж, хадгалах:
 - (i) тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшсэн байхыг шаарддаг ажилтны;
 - (ii) Даргын шилжүүлсэн эрх, эсхүл ажил үүргийг хэрэгжүүлж байгаа ажилтны;
 - (iii) гэрчилгээ эзэмшигчийн олгосон эрхийг хэрэгжүүлж байгаа ажилтны;
- (2) бүртгэлд дараах дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан байх:
 - (i) энэ хэсгийн (1)-д заасан ажилтны холбогдох туршлага, мэргэшил болон сургалт;
 - (ii) энэ хэсгийн (1)(i)-д заасан үнэмлэх, эсхүл зэрэглэлийн үйлчлэх хүрээ, хүчинтэй байдал болон хугацаа;
 - (iii) энэ хэсгийн (1)(ii)-т заасан, шилжүүлсэн эрх, үүрэг;
 - (iv) энэ хэсгийн (1)(iii)-т заасан эрх;
- (3) бүртгэлийг дараах өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хадгалах:
 - (i) тухайн ажилтан үнэмлэх, эсхүл зэрэглэл шаардсан ажил үүргээ гүйцэтгэхээ зогсоосон; эсхүл
 - (ii) аливаа шилжүүлсэн эрх, эсхүл зөвшөөрлийг хэрэгжүүлж байгаа.

119.69. Байгууламжийн бүртгэл

Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь:

- (1) тухайн гэрчилгээнд заасан үйл ажиллагааг гүйцэтгэхэд ашигладаг аюулгүй байдлын-эрсдэлтэй төхөөрөмжийн тест, шалгалт болон тохируулгыг үнэн зөв бүртгэдэг болохыг бататгах журмыг тогтооно;
- (2) энэ хэсгийн (1)-д шаардсан дэлгэрэнгүй мэдээллийн бүртгэлийг, бүртгэсэн өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хадгална.

119.71. Нислэгийн зөвшөөрөл болон хяналт

Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь нислэг, эсхүл хэд хэдэн нислэгийг санаачлах, үргэлжлүүлэх болон цуцлахыг 119.51(b)(1)(i)-д шаардсан этгээд зөвшөөрдөг болохыг бататгах журмыг тогтоосон байна.

119.73. Нислэг дагах хяналтын үйлчилгээ

(a) Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХҮ-ний нэгжид нислэгийн төлөвлөгөө хүргүүлэхгүйгээр гүйцэтгэдэг арилжааны нислэгийн үйл ажиллагааг нислэг дагах хяналтын үйлчилгээгээр хангадаг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь нислэг дагах хяналтын үйлчилгээгээр хангагдаж байгаа арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд, тухайн нислэг дагах хяналтын үйлчилгээг үзүүлж байгаа этгээдийг дараах шаардлага хангасан болохыг бататгах ёстой:

- (1) ИНД-91.307(с)-д шаардсан, VFR нислэгийн төлөвлөгөөний талаар мэдээлэлтэй байх;
- (2) арилжааны нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэж дуусах урьдчилан тохирсон цагтай байх;
- (3) энэ зүйлийн (с)-г харгалзан, хэрэв тухайн нислэгийг холбоо байнга хадгалах боломжгүй бүсэд гүйцэтгэх бол холбоог эргэн тогтоох цагтай байх;
- (4) тухайн нислэг дагах хяналтын үйлчилгээнд хөлгийн даргын мэдээлж болох үйл ажиллагааны аюулгүй байдалтай холбоотой бусад зохицуулалтын дэлгэрэнгүй мэдээлэлтэй байх;
- (5) хэрэв хөлгийн дарга энэ хэсгийн (2), (3), эсхүл (4)-ийн дагуу урьдчилан тохирсон цагт холбоо тогтоож чадаагүй бол, дараах байгууллагад цаг тухайд нь мэдээлэл өгдөг байх:
 - (i) онцгой байдлын зохицуулах төвд; эсхүл
 - (ii) Даргын хүлээн зөвшөөрөхүйц, онцгой нөхцөлийн арга хэмжээ авах чадвартай байгууллагад.

(с) Дарга илүү урт хугацааг хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд, агаарын хөлөг энэ зүйлийн (b)(3)-ын дагуу, 30 минутаас дээш хугацаагаар холбоогүй байж болохгүй.

119.75. Агаарын тээвэрлэгчийн Аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр

Монгол Улсаас, эсхүл Монгол Улсад, 9-өөс дээш зорчигчийн суудлын конфигурацитай (шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна) агаарын хөлгөөр агаарын тээврийн тогтмол нислэгийн зорчигч үйлчилгээ эрхлэхээр төлөвлөж байгаа шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-108-ын шаардлага хангасан агаарын тээвэрлэгчийн Аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

119.77. Үйл ажиллагааны журам тогтоох

Арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөж байгаа шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ Дүрэм, эсхүл бусад ИНД-ийн шаардлагыг хангахад шаардлагатай журмыг тогтоосон байна.

119.79. Аюулгүй байдлын удирдлага

Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрддөг байх үүрэгтэй.

119.81. Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий заавар

(а) Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг багтаасан Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад заавар нь дараах шаардлагыг хангасан болохыг бататган, хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:

- (i) энэ Дүрэм, холбогдох бусад ИНД-ийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулж, агаарын тээвэрлэгчийн байгууллагыг тодорхойлсон байх;
 - (ii) тухайн байгууллагын ажилтнууд түүнийг байнга дагаж мөрддөг байх;
- (1A) 119.79-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотойгоор:
- (i) ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;
 - (ii) Шугамын АТ-ийн гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;
- (2) 119.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтнуудын албан тушаал, нэр;
- (3) 119.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтнуудын дараах үүрэг, хариуцлага:
- (i) тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тэдний хариуцсан асуудал;
 - (ii) аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;
- (4) агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх зорилгоор хүсэлт гаргагчийн ажилтнуудын байрлаж байгаа байрлал дахь үйл ажиллагааны цар хүрээний хураангуй мэдээлэл;
- (5) 119.51(a)(1), (a)(2)-т шаардсан удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг энэ зүйлийн (a)(4)-т заасан ажлын байр бүрээр харуулсан байгууллагын бүтцийн зураг;
- (6) энэ зүйлийн (a)(4)-т заасан байрлал бүр дээрх ажилтнуудын бүтцийн хураангуй мэдээлэл;
- (6A) аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг байгууллагын хүрээнд тодорхойлсон мэдээлэл;
- (7) үйл ажиллагааны үндсэн байрлал, хэрэв хамааралтай бол, үйл ажиллагааны болон техник үйлчилгээний үндсэн баазын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (8) 119.55-д шаардсан байгууламжийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (9) энэ Дүрэмд шаардсан хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (10) дараах дэлгэрэнгүй мэдээлэл:
- (i) 119.61-д шаардсан техник үйлчилгээний журам;
 - (ii) 119.63-т шаардсан техник үйлчилгээний хөтөлбөр;
 - (iii) хүсэлт гаргагчийн агаарын хөлөгт техник үйлчилгээ гүйцэтгэдэг техник үйлчилгээний байгууллага;
- (11) шаардлагатай тохиолдолд, энэ Дүрэм болон ИНД-121, ИНД-125, эсхүл ИНД-135-д шаардсан аль холбогдох хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (12) хүсэлт гаргагчийн агаарын хөлөг нь үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа гадаад улсын хууль дүрмийг дагаж мөрддөг болохыг бататгах хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (13) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам.
- (b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

С Бүлэг - Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага

119.101. Ажилтанд тавих шаардлага

(a) Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах этгээдийг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:

(1) Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон дараах үүрэгтэй удирдах ажилтан:

(i) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа бүх үйл ажиллагааг санхүүжүүлэх ба энэ Дүрэмд заасан шаардлага болон стандартын дагуу гүйцэтгэж чадахаа хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах;

(ii) хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах;

(2) дараах удирдах ажилтнууд:

(i) хүсэлт гаргагчийн байгууллага нь Ерөнхий заавраа дагаж мөрдөж байгааг бататгах хариуцлага хүлээх;

(ii) энэ зүйлийн (b)(1)-д заасан ажил үүрэгт хариуцлага хүлээх;

(iii) Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх;

(3) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах болон гэрчилгээжүүлэх хангалттай тооны ажилтан.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан удирдах ажилтнууд нь дараах үүрэгтэй:

(1) Дарга өөр хэлбэрээр хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд, хүсэлт гаргагчийн байгууллагын хэмжээ, төлөвлөж байгаа үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалан дараах нэгээс ихгүй албан тушаалд хариуцлага хүлээх:

(i) нислэгийн үйл ажиллагаа болон газрын дэмжих үйл ажиллагааг багтаасан нислэг хариуцсан удирдах ажилтан;

(ii) багийн гишүүдийн сургалт болон ур чадварын үнэлгээ хариуцсан удирдах ажилтан;

(iii) техник үйлчилгээний удирдлага болон төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан;

(iv) 119.124-т шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан;

(v) хэрэг явдлыг ИНД-12-ын дагуу шинжлэн шалгах удирдах ажилтан;

(2) тэдний хариуцлага хүлээх ажил үүрэгт хамаарах, Хавсралт В-д заасан минимум мэргэшил болон туршлагыг эзэмшсэн байх.

(c) Энэ зүйлийн (b)(1)(ii)-ыг үл харгалзан, хэрэв хүсэлт гаргагчийн байгууллагын бүтцэд тохирох бол ур чадварын үнэлгээ хийх удирдах ажилтны үүрэг хариуцлагыг, энэ зүйлийн (b)(1)(i)-ийн дагуу нислэг хариуцсан удирдах ажилтанд нэгтгэж болно.

119.103. Ажилтны ур чадварын шаардлага

(а) Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:

- (1) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан арилжааны нислэгийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах, эсхүл гэрчилгээжүүлэх эрх бүхий ажилтны ур чадварт суурь үнэлгээ хийх болон түүнийг хадгалах;
- (2) ажилтнуудад тэдний эрхийн хүрээг нотолсон, бичгээр үйлдсэн баримт олгодог болохыг бататгах.

(b) Хүсэлт гаргагч нь, ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн бөгөөд энэ зүйлийн (а)(1)-ийн дагуу хүсэлт гаргагчийн ажилтны ур чадварыг хадгалах зорилгоор үнэлгээ хийх, эсхүл сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэх эрх зохих ёсоор олгогдсон байгууллагатай гэрээ байгуулж болно.

(c) Энэ зүйлийн (b)-гийн дагуу бусад байгууллагатай гэрээ байгуулсан хүсэлт гаргагч нь дараах дэлгэрэнгүй мэдээллийг Ерөнхий заавартаа оруулсан байна:

- (1) тухайн байгууллагад шилжүүлэх ажил үүрэг;
- (2) тухайн байгууллагын зохион байгуулах сургалт, эсхүл авах шалгалтын цар хүрээ;
- (3) сургалт зохион байгуулах болон шалгалт авахтай холбоотой байгууллагын эрх.

(d) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (b)-гийн оронд, зохих ёсоор мэргэшсэн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийн гүйцэтгэх, Даргын хүлээн зөвшөөрөхүйц гадны шалгалт, эсхүл сургалтын хөтөлбөрийг ашиглаж болно.

119.105. Байгууламжид тавих шаардлага

(а) Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц, дараах байгууламжтай байна:

- (1) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан үйл ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангах;
- (2) шаардлагатай тохиолдолд, дараах байгууламж болон төхөөрөмжийг багтаасан:
 - (i) захиргааны болон ажлын байр, засвар үйлчилгээний ажлын байр, ангар болон бусад барилга байгууламж;
 - (ii) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай төхөөрөмж, багаж хэрэгсэл, материал, сургалтын туслах хэрэгсэл, өгөгдөл болон баримт бичиг.

(b) Хүсэлт гаргагч нь дараах ажлын орчин нөхцөлийг бүрдүүлсэн болохыг бататгана:

- (1) гүйцэтгэх ажилд тохирсон;
- (2) шаардлагатай тохиолдолд, цаг агаарын нөхцөлөөс хамгаалагдсан.

119.107. Бататгах нислэг, эсхүл тест

(a) Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших, эсхүл гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт гаргагч нь, хэрэв Дарга шаардсан бол холбогдох шаардлагыг хангаж чадахаа батлах зорилгоор бататгах нислэг, эсхүл тест хийнэ.

(b) Тухайн нислэг, эсхүл тестийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр гүйцэтгэсэн байна.

119.109. Техник үйлчилгээний журам

(a) Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах агаарын хөлөг, төхөөрөмжийн НТЧ-ын хадгалалтыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

(1) тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлөг;

(2) тухайн агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл бэхэлсэн төхөөрөмж.

(b) Өөрийн агаарын хөлгийн техник үйлчилгээг бусад этгээдээр гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, 119.125-д шаардсан Ерөнхий зааварт дараах дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан байх үүрэгтэй:

(1) бусад этгээдэд шилжүүлэх ажил үүрэг;

(2) бусад этгээдийн гүйцэтгэх техник үйлчилгээний цар хүрээ;

(3) гүйцэтгэх ажил үүрэг, техник үйлчилгээтэй холбоотой бусад этгээдийн эрх.

119.111. Техник үйлчилгээний хөтөлбөр

(a) Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлөг бүрд зориулсан техник үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөр нь дараах мэдээллийг багтаасан байх ёстой:

(1) тухайн хөтөлбөрт хамрагдах агаарын хөлгийн маяг, бүртгэлийн болон серийн дугаар;

(2) агаарын хөлгийн хүчилсэн бүтэц, агаарын хөлгийн хөдөлгүүр, сэнс, даах сэнс, хэрэгсэл, ослын төхөөрөмжийн шаардлагатай үзлэг шалгалт, тест болон дараах эд анги, түүний байрлалын дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээг гүйцэтгэхэд зориулсан ИНД-91-ийн G Бүлэг болон үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарьт заасан минимум шаардлагатай дүйцэх зааварчилгаа, журам:

(i) үзлэг шалгалт хийсэн байх шаардлагатай;

(ii) хэрэв техник үйлчилгээг зохих ёсоор гүйцэтгээгүй бол, эсхүл хэрэв зориулалтын бус материал, эсхүл эд анги ашигласан бол тухайн агаарын хөлгийн аюулгүй үйл ажиллагаанд аюул учруулах татгалзал, доголдол, эсхүл гэмтэлд хүргэж болох;

- (3) ашиглалтын цаг, цикл, хуанлийн хугацаа болон үйл ажиллагааны системийн тоо, эсхүл тэдгээрийн аливаа хослолоор илэрхийлэгдэх, энэ зүйлийн (b)(2)-ын дагуу техник үйлчилгээ гүйцэтгэх хуваарь;
- (4) агаарын хөлгийг техник үйлчилгээний хөтөлбөрт шилжүүлэх журам;
- (5) хэрэв тухайн хөтөлбөр нь нөхцөлөөр хянах техник үйлчилгээ (condition monitored maintenance), эсхүл үзүүлэлт болон ашиглалтын мониторингийн (health and usage monitoring) системээс гарсан мэдээллийг ашигладаг бол техник үйлчилгээний чиг хандлагад (трэнд) дүн шинжилгээ хийх журам;
- (6) техник үйлчилгээний хөтөлбөрт шаардсан үзлэг шалгалтыг хийдэг болохыг бататгах журам;
- (7) бүртгэл хөтлөх жишээг багтаасан, гэмтлийг бүртгэх журам;
- (8) гэмтлийг засах, эсхүл түүнийг хойшлуулах журам;
- (9) ашиглалтын туршлагад үндэслэн үзлэг шалгалтын үечлэлийг өөрчлөх журам;
- (10) ИНД-91.623-ын дагуу техник үйлчилгээний бүртгэлийг хадгалах журам.

119.113. Баримт бичиг

(a) Энэ дүрмийн 119.124(с)-гийн дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой байхыг шаарддаг, Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь өөрийн үйл ажиллагаа, аюулгүй байдал болон техник үйлчилгээний өгөгдлийг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах, түгээх журмыг тогтоосон байна.

(b) Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-91, ИНД-135-ыг багтаасан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй, холбогдох бусад ИНД-ээр шаардсан баримт бичгийн хяналтын журмыг тогтоосон байна.

(c) Энэ зүйлийн (a), (b)-д шаардсан журам нь дараах шаардлагыг бататгана:

- (1) бүх баримт бичгийг боловсруулж гаргахаас өмнө холбогдох этгээд хянаж, зөвшөөрдөг байх;
- (2) бүх холбогдох баримт бичгийн хүчинтэй хувийг, шаардлагатай бүх байрлалд ажилтан авч ашиглахад хэвлэмэл, цахим, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр бэлэн байлгах;
- (3) хүчингүй болсон бүх баримт бичгийг боловсруулж гаргасан, эсхүл ашиглаж байгаа цэг бүрээс нэн даруй хураан авдаг байх;
- (4) тухайн баримт бичгийн өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж, зөвшөөрдөг байх;
- (5) өөрчлөгдөж хүчингүй болсон материалыг ашиглахаас сэргийлж, баримт бичгийн хуудас бүрийн хүчинтэй хувилбарыг таньж тогтоож болдог байх.

119.115. Ажилтны бүртгэл

Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) дараах бүртгэлийг үнэн зөв хөтөлж, хадгалах:
 - (i) тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшсэн байхыг шаарддаг ажилтны;

- (ii) Даргын шилжүүлсэн эрх, эсхүл ажил үүргийг хэрэгжүүлж байгаа ажилтны;
- (iii) гэрчилгээ эзэмшигчийн олгосон эрхийг хэрэгжүүлж байгаа ажилтны;
- (2) бүртгэлд дараах дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан байх:
 - (i) энэ хэсгийн (1)-д заасан ажилтны холбогдох туршлага, мэргэшил болон сургалт;
 - (ii) энэ хэсгийн (1)(i)-д заасан үнэмлэх, эсхүл зэрэглэлийн үйлчлэх хүрээ, хүчинтэй байдал болон хугацаа;
 - (iii) энэ хэсгийн (1)(ii)-т заасан, шилжүүлсэн эрх, үүрэг;
 - (iv) энэ хэсгийн (1)(iii)-т заасан эрх;
- (3) бүртгэлийг дараах өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хадгалах:
 - (i) тухайн ажилтан үнэмлэх, эсхүл зэрэглэл шаардсан ажил үүргээ гүйцэтгэхээ зогсоосон; эсхүл
 - (ii) шилжүүлсэн эрх, эсхүл зөвшөөрлийг хэрэгжүүлж байгаа.

119.117. Байгууламжийн бүртгэл

Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь:

- (1) тухайн гэрчилгээнд заасан үйл ажиллагааг гүйцэтгэхэд ашигладаг аюулгүй байдлын-эрсдэлтэй төхөөрөмжийн тест, шалгалт болон тохируулгыг үнэн зөв бүртгэдэг болохыг бататгах журмыг тогтооно;
- (2) энэ хэсгийн (1)-д шаардсан дэлгэрэнгүй мэдээллийн бүртгэлийг, бүртгэсэн өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хадгална.

119.119. Нислэгийн зөвшөөрөл болон хяналт

Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь нислэг, эсхүл хэд хэдэн нислэгийг санаачлах, үргэлжлүүлэх болон цуцлахыг 119.101(b)(1)(i)-д шаардсан этгээд зөвшөөрдөг болохыг бататгах журмыг тогтоосон байна.

119.121. Нислэг дагах хяналтын үйлчилгээ

(a) Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХҮ-ний нэгжид нислэгийн төлөвлөгөө хүргүүлэхгүйгээр гүйцэтгэдэг арилжааны нислэгийн үйл ажиллагааг нислэг дагах хяналтын үйлчилгээгээр хангадаг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь нислэг дагах хяналтын үйлчилгээгээр хангагдаж байгаа арилжааны нислэгийн үйл ажиллагааны хувьд, тухайн нислэг дагах хяналтын үйлчилгээг үзүүлж байгаа этгээдийг дараах шаардлага хангасан болохыг бататгах ёстой:

- (1) ИНД-91.307(c)-д шаардсан, VFR нислэгийн төлөвлөгөөний талаар мэдээлэлтэй байх;
- (2) арилжааны нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэж дуусах урьдчилан тохирсон цагтай байх;
- (3) энэ зүйлийн (c)-г харгалзан, хэрэв тухайн нислэгийг холбоо байнга хадгалах боломжгүй бүсэд гүйцэтгэх бол холбоог эргэн тогтоох цагтай байх;

- (4) тухайн нислэг дагах хяналтын үйлчилгээнд хөлгийн даргын мэдээлж болох үйл ажиллагааны аюулгүй байдалтай холбоотой бусад зохицуулалтын дэлгэрэнгүй мэдээлэлтэй байх;
- (5) хэрэв хөлгийн дарга энэ хэсгийн (2), (3), эсхүл (4)-ийн дагуу урьдчилан тохирсон цагт холбоо тогтоож чадаагүй бол, дараах байгууллагад цаг тухайд нь мэдээлэл өгдөг байх:
- (i) онцгой байдлын зохицуулах төвд; эсхүл
 - (ii) Даргын хүлээн зөвшөөрөхүйц, онцгой нөхцөлийн арга хэмжээ авах чадвартай байгууллагад.
- (c) Агаарын хөлөг нь энэ зүйлийн (b)(3)-ын дагуу, дараах хугацаагаар холбоогүй байж болно:
- (1) хэрэв агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол 30 минутаас дээшгүй хугацаанд; эсхүл
 - (2) хэрэв тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол (a)-д заасан журмын дагуу тухайн нислэг эхлэхийн өмнө тогтоосон аливаа хугацаанд.

119.123. Үйл ажиллагааны журмыг тогтоох

Арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөж байгаа ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ Дүрэм, эсхүл бусад ИНД-ийн шаардлагыг хангахад шаардлагатай журмыг тогтоосон.

119.124. Аюулгүй байдлын удирдлага

Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрддөг байх үүрэгтэй.

119.125. Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий заавар

- (a) Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг багтаасан Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:
- (1) Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад заавар нь дараах шаардлагыг хангасан болохыг бататган, хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:
 - (i) энэ Дүрэм, холбогдох бусад ИНД-ийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулж, агаарын тээвэрлэгчийн байгууллагыг тодорхойлсон байх;
 - (ii) тухайн байгууллагын ажилтнууд түүнийг байнга дагаж мөрддөг байх;
 - (1A) 119.124-т шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотойгоор:
 - (i) ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;
 - (ii) ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;

- (2) 119.101(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтнуудын албан тушаал, нэр;
 - (3) 119.101(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтнуудын дараах үүрэг, хариуцлага:
 - (i) тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тэдний хариуцсан асуудал;
 - (ii) аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;
 - (4) хэрэв хамааралтай бол, 119.101(а)(1) болон (а)(2)-т шаардсан удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;
 - (4А) аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг байгууллагын хүрээнд тодорхойлсон мэдээлэл;
 - (5) үйл ажиллагааны үндсэн байрлал, хэрэв хамааралтай бол, үйл ажиллагааны болон техник үйлчилгээний үндсэн баазын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (6) энэ Дүрэмд шаардсан хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (7) дараах дэлгэрэнгүй мэдээлэл:
 - (i) 119.109-д шаардсан техник үйлчилгээний журам;
 - (ii) 119.111-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөр;
 - (iii) хүсэлт гаргагчийн агаарын хөлөгт техник үйлчилгээ гүйцэтгэдэг техник үйлчилгээний байгууллага;
 - (8) шаардлагатай тохиолдолд, энэ Дүрэм болон ИНД-135-д шаардсан аль холбогдох хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (9) хүсэлт гаргагчийн агаарын хөлөг нь үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа гадаад улсын хууль дүрмийг дагаж мөрддөг болохыг бататгах хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (10) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам.
- (b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

D Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага

119.151. Байнгын хэрэгжилт

- (a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь 119.15-д шаардсан Үйл ажиллагааны тодорхойлолтыг дагаж мөрдөх үүрэгтэй.
- (b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:
- (1) В Бүлэг, эсхүл С Бүлгийн аль холбоотой шаардлагыг дагаж мөрдөн, стандартыг тогтмол хангах;
 - (2) Ерөнхий заавартаа дэлгэрэнгүй заасан хөтөлбөр болон журмыг дагаж мөрдөх;
 - (3) Ерөнхий заавартаа заасан байрлал бүрд:
 - (i) Үйл ажиллагааны тодорхойлолтын 1-ээс доошгүй хүчинтэй хувийг хадгалах;
 - (ii) Ерөнхий зааврын, тухайн байрлал дахь үйл ажиллагаанд хамаарах хэсгийн 1-ээс доошгүй хүчинтэй хувийг хэвлэмэл, цахим, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр хадгалах.

119.153. Нислэгийн үйл ажиллагааны шаардлага

- (a) Арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг дагаж мөрдөнө:
- (1) шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна, 30-аас дээш зорчигчийн суудлын конфигурацитай, эсхүл төлбөрт ачааллын багтаамж нь 3410 кг-аас дээш жинтэй нисэх онгоцны хувьд, ИНД-121-ийн холбогдох үйл ажиллагааны шаардлага;
 - (2) шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна, 10 - 30 зорчигчийн суудлын конфигурацитай, эсхүл төлбөрт ачааллын багтаамж нь 3410 кг, эсхүл түүнээс доош ба МСТOW нь 5700 кг-аас дээш жинтэй нисэх онгоцны хувьд, ИНД-125-ын холбогдох үйл ажиллагааны шаардлага;
 - (3) шаардлагатай багийн гишүүний суудлаас гадна, 9, эсхүл түүнээс цөөн зорчигчийн суудлын конфигурацитай, МСТOW нь 5700 кг, эсхүл түүнээс доош жинтэй нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэгний хувьд, энэ зүйлийн (b)-г харгалзан, ИНД-135-ын холбогдох үйл ажиллагааны шаардлага.
- (b) SEIFR-аар зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж байгаа шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-125-ын холбогдох үйл ажиллагааны шаардлагыг дагаж мөрдөнө.
- (c) Арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-135-ын холбогдох үйл ажиллагааны шаардлагыг дагаж мөрдөнө.

119.155. Нисэх багийн гишүүний мэргэшил

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай эрхийг багтаасан ИНД-61-ийн дагуу үнэмлэх болон зэрэглэл эзэмшдэггүй этгээдийг арилжааны нислэгийн үйл ажиллагаанд нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй бөгөөд тухайн этгээд нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэхгүй.

(b) Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх зөвшөөрөлтэй этгээд нь энэ зүйлийн (a)-д шаардсан мэргэжлийн үнэмлэх, хүчинтэй эрүүл мэндийн гэрчилгээг биедээ авч явна.

119.157. Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн чартер, давхар-түрээс болон түрээс

(a) Бусад АТ-ийн гэрчилгээ эзэмшигчээс агаарын хөлгийг нисэх багтай, эсхүл нисэх баггүйгээр чартер хийх, давхар-түрээслэх, эсхүл түрээслэх АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн агаарын хөлгийг арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашиглахын өмнө тухайн үйл ажиллагааг аль АТ-ийн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэхийг холбогдох үйл ажиллагаа эрхлэгчтэй хамтран тодорхой тогтоож, хөлгийн даргад мэдэгдэнэ.

(b) Агаарын хөлгийг АТ-ийн гэрчилгээ эзэмшдэггүй этгээдээс нисэх багтай, эсхүл нисэх баггүйгээр чартер хийх, давхар-түрээслэх, эсхүл түрээсэлж байгаа АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн үйл ажиллагааг өөрийн АТ-ийн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэнэ.

(c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхээр бичгээр үйлдсэн чартер, давхар-түрээс, эсхүл түрээсийн зохицуулалтын хувийг, тухайн зохицуулалтын дагуу сүүлчийн нислэг үйлдсэн өдрөөс хойш 1-ээс доошгүй жилийн хугацаанд хадгална.

(d) Чартер, давхар-түрээс, эсхүл түрээсийн зохицуулалтыг амаар хийсэн тохиолдолд, АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь зохицуулалтын нөхцөлийг тогтоосон санамж бичиг, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг, тухайн зохицуулалтын дагуу сүүлчийн нислэг үйлдсэн өдрөөс хойш 1 жилээс доошгүй хугацаагаар хадгална.

119.159. Монгол Улсын бүртгэлгүй агаарын хөлөг ашиглах

(a) Арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Монгол Улсын бүртгэлгүй агаарын хөлгийг чартер, түрээс, эсхүл бусад ижил төстэй зохицуулалтаар ашиглах АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь илүү богино хугацаа нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байхаас бусад тохиолдолд, тухайн үйл ажиллагааг эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө чартер, түрээс, эсхүл бусад ижил төстэй зохицуулалтын үндсэн нөхцөл болон дараах мэдээллийг Даргад мэдэгдэнэ:

- (1) тухайн агаарын хөлгийг нийлүүлэгч нь ICAO-гийн хэлэлцэн тохирогч Улсаас олгосон арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эсэх;
- (2) тухайн зохицуулалтад оролцогч талуудын нэр;
- (3) тухайн зохицуулалтын үргэлжлэх хугацаа;

(4) тухайн зохицуулалтад оролцож байгаа агаарын хөлгийн үндэсний харьяалал, бүртгэлийн дугаар болон маяг.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь арилжааны нислэгийн үйл ажиллагаанд Монгол Улсын бүртгэлгүй агаарын хөлөг ашиглахаас өмнө Даргаас зөвшөөрөл авна.

119.161. Бизнесийн, эсхүл худалдааны нэр

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь арилжааны нислэгийн үйл ажиллагааг гэрчилгээнд заасан худалдааны, эсхүл бизнесийн нэрээр эрхэлнэ.

(b) Тухайн үйл ажиллагаа эрхэлж байгаа гэрчилгээ эзэмшигчийн худалдааны, эсхүл бизнесийн нэрийг тухайн агаарын хөлөгт суухын өмнө тухайн зорчигчид ил харагдахуйц, танигдахуйц, гаргацтай хэлбэрээр байрлуулснаас бусад тохиолдолд, аливаа этгээд арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэхгүй.

(c) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь өөрийн гүйцэтгэдэг арилжааны нислэгийн үйл ажиллагааны зар сурталчилгааг хийхдээ гэрчилгээнд заасан хууль ёсны бизнесийн, эсхүл худалдааны нэрийг тодорхой харуулна.

119.163. Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн хязгаарлалт

Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшдэг байхаас бусад тохиолдолд ИНД-121, эсхүл ИНД-125-д хамаарах үйл ажиллагааг эрхлэхгүй.

119.165. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт

(a) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

- (1) Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлтийг тухайн байгууллагын тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар хийдэг болохыг бататгах;
- (2) Ерөнхий зааварт оруулсан нэмэлт өөрчлөлтийг энэ Дүрэм, эсхүл бусад ИНД-ийн холбогдох шаардлагад нийцэж байгаа ба Ерөнхий зааварт агуулагдсан нэмэлт өөрчлөлт оруулах журмын дагуу хийдэг болохыг бататгах;
- (3) Ерөнхий зааварт нэмэлт, өөрчлөлт оруулсан даруйд тухайн нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргын хэрэгцээнд зориулж цаг алдалгүй хүргүүлэх;
- (4) нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт өөрчлөлтийг Ерөнхий заавартаа оруулах.

(b) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхийн өмнө Даргын зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:

- (1) Гүйцэтгэх захирал;
- (2) нэр заагдсан удирдах ажилтнууд;
- (3) 119.81(а)(7), эсхүл 119.125(а)(5)-ын аль хамааралтай Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан, тухайн гэрчилгээ эзэмшигчийн арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхэлдэг байрлал;
- (4) гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээний цар хүрээ;

- (5) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, хэрэв тухайн өөрчлөлт нь нөлөө бүхий өөрчлөлт бол;
- (6) [хүчингүй]
- (7) техник үйлчилгээний хөтөлбөр;
- (8) гэрчилгээ эзэмшигчийн техник үйлчилгээг гүйцэтгэдэг, эсхүл сургалтыг зохион байгуулдаг гэрээт байгууллага;
- (9) нислэгийн болон ажил үүргийн цагийн хуваарь;
- (10) шаардлагатай тохиолдолд, агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр.

(c) [хүчингүй]

(d) Дарга, энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл хийсний дараа АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн дагаж мөрдөх нөхцөлийг тогтоож болно.

(e) АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (d)-гийн дагуу Даргын тогтоосон аливаа нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.

(f) Хэрэв энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлт нь АТ-ийн гэрчилгээ, эсхүл Үйл ажиллагааны тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг шаардаж байгаа бол АТ-ийн гэрчилгээ эзэмшигч тухайн гэрчилгээ, эсхүл Үйл ажиллагааны тодорхойлолтод зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.

119.167. Техник үйлчилгээний хөтөлбөрт өөрчлөлт оруулах

АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь, Дарга тухайн хөтөлбөрийн НТЧ-ын хадгалалтын шаардлагыг хангахад шаардлагатай гэж үзсэн өөрчлөлтийг Даргын шаардсан даруйд техник үйлчилгээний хөтөлбөртөө оруулна.

119.201. ИНД-121, эсхүл ИНД-125-ын үйл ажиллагаа эрхэлдэг шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт

(a) Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна:

- (1) ИНД-121.1, эсхүл ИНД-125.1-д заасан үйл ажиллагаа эрхэлж байгаа шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч;
- (2) ИНД-121.1, эсхүл ИНД-125.1-д заасан үйл ажиллагаа эрхлэхээр шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч.

(b) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжүүлэлтийн хугацаанаас өмнө, энэ зүйлд хамаарах байгууллагыг дараах заалтыг мөрдөхийг шаардахгүй:

- (1) 119.51(b)(1)(iv), хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;
- (2) 119.79, хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон хадгалахын оронд 119.205-д нийцсэн дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол;
- (3) 119.81(a)(1A)(i);
- (4) 119.81(a)(3)(ii);

(5) 119.81(a)(6A).

(c) Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч болон шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь гүйцэд бөглөсөн САА маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг 2020 оны 4 сарын 1-нээс өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.

(d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангасан байх ёстой:

- (1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон хугацааг багтаасан байх;
- (2) тухайн байгууллага 119.79-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.

(e) Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол, Дарга:

- (1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;
- (2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх хугацааг тогтооно.

(f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу хугацааг тогтоохдоо Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:

- (1) тухайн байгууллагын хүчин чадал;
- (2) тухайн байгууллагын төвөгшил;
- (3) тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл;
- (4) аливаа гэрчилгээ сунгах хугацаа;
- (5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр, эсхүл хуваарийн нөлөө;
- (6) хэрэгжүүлэлтийн хугацаа нь 2021 оны 2 сарын 1-нээс хойш байж болохгүй.

(g) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтэд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргах шаардлагагүй.

(h) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

119.203. ИНД-135-ын үйл ажиллагаа эрхэлж байгаа шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт

(a) Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна:

- (1) ИНД-135.1-д заасан үйл ажиллагаа эрхэлж байгаа шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч;
- (2) ИНД-135.1-д заасан үйл ажиллагаа эрхлэхээр шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч.

(b) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжүүлэлтийн хугацаанаас өмнө, энэ зүйлд хамаарах байгууллагыг дараах заалтыг мөрдөхийг шаардахгүй:

- (1) 119.51(b)(1)(iv), хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;
- (2) 119.79, хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон хадгалахын оронд 119.205-д нийцсэн дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол;

- (3) 119.81(a)(1A)(i);
- (4) 119.81(a)(3)(ii);
- (5) 119.81(a)(6A).

(c) Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч болон шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь гүйцэд бөглөсөн САА маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг 2020 оны 4 сарын 1-нээс өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.

(d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангасан байх ёстой:

- (1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон хугацааг багтаасан байх;
- (2) тухайн байгууллага 119.79-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.

(e) Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол, Дарга:

- (1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;
- (2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх хугацааг тогтооно.

(f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу хугацааг тогтоохдоо, Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:

- (1) тухайн байгууллагын хүчин чадал;
- (2) тухайн байгууллагын төвөгшил;
- (3) тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл;
- (4) аливаа гэрчилгээ сунгах хугацаа;
- (5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр, эсхүл хуваарийн нөлөө;
- (6) хэрэгжүүлэлтийн хугацаа нь 2021 оны 2 сарын 1-нээс хойш байж болохгүй.

(g) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтэд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргах шаардлагагүй.

(h) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

119.205. Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн дотоод чанар баталгаажуулалтын шилжилт

(a) Энэ Дүрмээр шаардсан журам нь дүрмийн шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор, 119.201(b)(1)(ii), эсхүл 119.203(b)(1)(ii)-т шаардсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх үүрэгтэй.

(b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журмыг багтаасан байх ёстой:

- (1) ИНД-12-ын дагуу гүйцэтгэдэг хэрэг явдлыг шинжлэн шалгах журмыг багтаасан **аюулгүй байдлын бодлого** болон аюулгүй байдлын бодлогын журам;

- (2) тухайн тогтолцоонд оршин байгаа хүндрэлтэй асуудал, эсхүл хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг тогтоох зорилгоор гэмтэл, зөрчлийн мэдээлэл болон ажилтан, үйлчлүүлэгчдийн санал хүсэлтэд мониторинг хийдэг болохыг багтаасан **чанарын үзүүлэлтийг** бататгах журам;
 - (3) тухайн тогтолцоонд илрүүлсэн хүндрэлтэй асуудлыг засаж залруулдаг болохыг бататгах **залруулах арга хэмжээний** журам;
 - (4) тухайн тогтолцоонд илрүүлсэн хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг арилгадаг болохыг бататгах **урьдчилан сэргийлэх арга хэмжээний** журам;
 - (5) Ерөнхий зааварт заасан журмын нийцэл, аюулгүй байдлын бодлогод тусгасан зорилтын хэрэгжилтийг хүсэлт гаргагчийн байгууллагад хянах **дотоод аудитын хөтөлбөр**;
 - (6) энэ Дүрмийн шаардлагыг хангаж байгаа дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны үр дүнтэй байдал, цаашдын оновчтой байдлыг бататгах, статистикийн дүн шинжилгээний ашиглалтыг багтаасан **удирдлагын дүгнэлт хийх** журам.
- (c) Аюулгүй байдлын бодлогын журам нь, тухайн аюулгүй байдлын бодлогыг байгууллагын бүх түвшинд ойлгодог, хэрэгжүүлдэг ба хадгалдаг болохыг бататгах ёстой.
- (d) Залруулах арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байх шаардлагатай:
- (1) оршин байгаа хүндрэлтэй асуудлыг засаж залруулах;
 - (2) засаж залруулах арга хэмжээний үр дүнг эргэн нягтлах.
- (e) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байх шаардлагатай:
- (1) хүндрэл үүсгэж болох асуудлыг засаж залруулах;
 - (2) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг эргэн нягтлах;
 - (3) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд үндэслэн, энэ Дүрмээр шаардсан журамд нэмэлт өөрчлөлт оруулах.
- (f) Чанарын дотоод аудитын хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
- (1) аудит хийх үйл ажиллагааны шинж чанарыг тооцон, аудит хийх байршил, давтамжийг тогтоох;
 - (2) аудит хийгдэж байгаа үйл ажиллагааг шууд хариуцдаг этгээдээс хамааралгүй бие даасан, сургалтад хамрагдсан аудитын ажилтан тухайн аудитыг хийдэг болохыг бататгах;
 - (3) аудитын үр дүнг, аудит хийсэн үйл ажиллагаа хариуцсан удирдах ажилтан болон дотоод аудит хариуцсан удирдах ажилтанд тайлагнадаг болохыг бататгах;
 - (4) сүүлчийн аудитаас хойш, аудит хийгдсэн тухайн ажиллагааг хариуцсан ажилтны авсан урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээний үр дүнг үнэлж, дүгнэдэг байх;

- (5) хэрэв аудитаар хүндрэлтэй асуудал илэрсэн бол аудит хийсэн үйл ажиллагаа хариуцсан этгээдээс урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээ авахыг шаардах;
- (6) урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээний үр дүнтэй байдлыг дүгнэх зорилгоор эргэн нягтлах аудит хийдэг болохыг бататгах.
- (g) Удирдлагын дүгнэлт хийх журам нь дараах шаардлагыг багтаасан байх ёстой:
- (1) тухайн тогтолцооны цаашдын үр дүнтэй байдлын хэрэгцээ шаардлагыг тооцон, чанар баталгаажуулалтын тогтолцоонд удирдлагын дүгнэлт хийх давтамжийг тогтоох;
- (2) чанар баталгаажуулалтын тогтолцоонд дүгнэлт хийхийг хариуцсан ажилтныг тогтоох;
- (3) үнэлгээний үр дүнг бүртгэж, дүгнэдэг болохыг бататгах.
- (h) Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь аюулгүй байдалд нөлөөлөх асуудлаар Гүйцэтгэх захиралтай шууд харьцдаг байх үүрэгтэй.
- (i) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

119.207. Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч болон хүсэлт гаргагчийн шилжилт

- (a) Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна:
- (1) ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч;
- (2) ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч.
- (b) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжилтийн хугацаанаас өмнө, энэ зүйлд хамаарах байгууллагыг дараах заалтыг мөрдөхийг шаардахгүй:
- (1) 119.101(b)(1)(iv), хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд байгууллагын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтантай бол;
- (2) 119.124, хэрэв тухайн байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон хадгалахын оронд 119.209-д нийцсэн байгууллагын удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн бол;
- (3) 119.125(a)(1A)(i);
- (4) 119.125(a)(3)(ii);
- (5) 119.125(a)(6A).
- (c) Гүйцэд бөглөсөн САА маягт, хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг дараах хугацаанд Даргад хүргүүлэх үүрэгтэй:
- (1) энэ зүйлийн (a)(2)-ын дагуу ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагчийн хувьд, 2019 оны 7 сарын 30-наас хойш.
- (2) энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн хувьд, 2019 оны 7 сарын 30-наас өмнө.
- (d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангасан байх ёстой:

- (1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон хугацааг багтаасан байх;
 - (2) тухайн байгууллага 119.124-т шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.
- (e) Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол, Дарга:
- (1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;
 - (2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн хугацааг тогтооно.
- (f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу хугацааг тогтоохдоо, Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:
- (1) тухайн байгууллагын хүчин чадал;
 - (2) тухайн байгууллагын төвөгшил;
 - (3) тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл;
 - (4) аливаа гэрчилгээ сунгах хугацаа;
 - (5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр, эсхүл хуваарийн нөлөө;
 - (6) хэрэгжүүлэлтийн хугацаа нь 2021 оны 2 сарын 1-нээс хойш байж болохгүй.
- (g) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтэд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргах шаардлагагүй.
- (h) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

119.209. Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигч, эсхүл хүсэлт гаргагчийн байгууллагын удирдлагын тогтолцооны шилжилт

- (a) Энэ Дүрмээр шаардсан журмуудыг тухайн байгууллага хэрэгжүүлдэг ба үйл ажиллагаанд нь тохирч байгааг бататгах зорилгоор 119.207(b)(1)(ii)-т шаардсан байгууллагын удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байх ёстой.
- (b) Байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ болон төвөгшлөөс шалтгаалан, холбогдох байгууллагын үйл ажиллагааны журмыг байгууллагын бүх түвшинд ойлгодог, хэрэгжүүлдэг ба хадгалдаг болохыг бататгах зорилгоор тухайн байгууллагын удирдлагын тогтолцооны журам нь дэлгэрэнгүй байх ёстой.
- (c) Энэ зүйлийн (e)-д зааснаас бусад тохиолдолд, байгууллагын удирдлагын тогтолцоо нь дараах журмыг багтаасан байх ёстой:
- (1) ИНД-12-ын дагуу гүйцэтгэдэг хэрэг явдлыг шинжлэн шалгах журмыг багтаасан аюулгүй байдлын бодлого болон аюулгүй байдлын бодлогын журам;
 - (2) тухайн тогтолцоонд оршин байгаа хүндрэлтэй асуудал, эсхүл хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг тогтоох зорилгоор ажилтан, үйлчлүүлэгчдийн санал хүсэлтэд мониторинг хийдэг болохыг бататгах журам;
 - (3) тухайн тогтолцоонд илрүүлсэн хүндрэлтэй асуудал, эсхүл хүндрэл үүсгэж болох асуудлыг:
 - (i) залруулдаг байх журам;

- (ii) аливаа залруулга нь үр дүнтэй болсныг бататгах зорилгоор шалгадаг байх журам.
- (4) тухайн байгууллагын хөтөлбөр болон журам нь түүний аюулгүй байдлын бодлогод заасан зорилгод хүрч байгааг шалгах журам;
- (5) тухайн байгууллагын удирдлагын үйл ажиллагаа нь энэ Дүрмийн шаардлагыг хангахад үр дүнтэй хэвээр байгааг бататгах дараах төлөвлөгөө болон мэдээллийг багтаасан журам:
 - (i) дүгнэлт хийх байнгын төлөвлөгөө;
 - (ii) илрүүлсэн хүндрэлтэй асуудлыг залруулах зорилгоор, хийсэн дүгнэлтийн үр дүн болон авсан аливаа арга хэмжээг багтаасан, ажилтнуудад тогтмол эргэж мэдээлдэг байх.
- (d) Байгууллагын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан нь аюулгүй байдалд нөлөөлөх асуудлаар Гүйцэтгэх захиралтай шууд харьцах үүрэгтэй.
- (e) Энэ зүйлийн (c) нь дараах арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсхүл эрхлэхээр төлөвлөж байгаа байгууллагад хамаарахгүй:
 - (1) Үйл ажиллагааны тодорхойлолтод нь 3, эсхүл түүнээс цөөн агаарын хөлөг багтсан;
 - (2) нийт 2, эсхүл түүнээс цөөн баазтай.
- (f) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

Хавсралт А - Шугамын АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн удирдах ажилтны мэргэшил болон туршлага

Энэ Хавсралт нь 119.51(b)(1)(i), (ii), (iii) болон (iv)-ийн дагуу үүрэг хариуцлага хүлээх удирдах ажилтны мэргэшил болон туршлагын шаардлагыг тогтооно.

А.1. Нислэг хариуцсан удирдах ажилтан

ИНД-121-ийн үйл ажиллагаа		
Шаардлагатай баримт	бичиг	Агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхтэй (ATPL) байх
Хөлгийн туршлага	даргын	3 жил, ИНД-121-ийн үйл ажиллагааны хүрээнд хөлгийн даргаар ниссэн туршлагатай байх
Удирдан байгуулах туршлага	зохион	3 жил, нислэгийн үйл ажиллагааны хяналтын үүргийг гүйцэтгэсэн байх

	ИНД-125-ын үйл ажиллагаа		ИНД-135-ын үйл ажиллагаа
	Олон гишүүнтэй баг	Ганц-нисгэгчтэй	
Шаардлагатай баримт бичиг	Агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхтэй (ATPL) байх	Хэрэглэлийн зэрэглэлтэй коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй (CPL) байх, хэрэв үйл ажиллагаанд IFR багтдаг бол	Хавсралт В-г харах
Хөлгийн даргын туршлага	3 жил, ИНД-121, 125, эсхүл 135-ын дагуу үйл ажиллагаанд хөлгийн даргаар ниссэн туршлагатай байх; эсхүл ↓	3 жил, ИНД-121, 125, эсхүл 135-ын дагуу үйл ажиллагаанд хөлгийн даргаар ниссэн туршлагатай байх; эсхүл ↓	Хавсралт В-г харах
Удирдах ажлын туршлага	3 жил, нислэгийн үйл ажиллагааны хяналтын үүрэг гүйцэтгэсэн байх	3 жил, нислэгийн үйл ажиллагааны хяналтын үүрэг гүйцэтгэсэн байх	Хавсралт В-г харах

А.2. Багийн гишүүдийн сургалт болон ур чадварын үнэлгээ хариуцсан удирдах ажилтан

ИНД-121-ийн үйл ажиллагаа	
Шаардлагатай баримт бичиг	Холбогдох зэрэглэлтэй агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхтэй (ATPL) байх
Хүчинтэй байдал	Үйл ажиллагаа эрхлэгчийн агаарын хөлгийн нэг маяг дээр даргын үүрэг гүйцэтгэдэг байх
Туршлага	3 жил, ИНД-121, 125, эсхүл 135-ын үйл ажиллагаанд хөлгийн даргаар ниссэн туршлагатай байх ба 2 жил, нислэгийн шалгалт авсан ба сургалт зохион байгуулсан туршлагатай байх

	ИНД-125-ын үйл ажиллагаа		ИНД-135-ын үйл ажиллагаа
	Олон гишүүнтэй баг	Ганц-нисгэгчтэй	
Шаардлагатай баримт бичиг	Холбогдох зэрэглэлтэй агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхтэй (ATPL) байх	Хэрэглэлийн зэрэглэлтэй коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй (CPL) байх, хэрэв үйл ажиллагаанд IFR багтдаг бол	Хавсралт В-г харах
Хүчинтэй байдал	Үйл ажиллагаа эрхлэгчийн агаарын хөлгийн нэг маяг дээр хөлгийн даргын үүрэг гүйцэтгэдэг байх		Хавсралт В-г харах
Туршлага	3 жил, ИНД-121, 125, эсхүл 135-ын үйл ажиллагаанд хөлгийн даргаар ниссэн туршлагатай байх ба 2 жил, нислэгийн шалгалт авсан ба сургалт зохион байгуулсан туршлагатай байх		Хавсралт В-г харах

Хэрэв тухайн этгээд нь АТ-ийн гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэж байгаа агаарын тээврийн үйл ажиллагааны дүйцэх туршлагатай, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц, дүйцэх төрлийн үйл ажиллагааны туршлагатай бол түүнийг ИНД-121, ИНД-125, эсхүл ИНД-135-ын үйл ажиллагааны туршлагын шаардлага хангасан гэж үнэлгээ хийж болно.

А.3. Техник үйлчилгээний удирдлага болон төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан

А.3.1. ИНД-121-ийн үйл ажиллагаа

(а) ИНД-121-ийн дагуу арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа байгууллагын техник үйлчилгээний удирдлага болон төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан нь дараах шаардлага хангасан байх үүрэгтэй:

- (1) байгууллагын Ерөнхий зааврын техник үйлчилгээнд хамааралтай хэсэг болон ИНД-121-ийн техник үйлчилгээний холбогдох шаардлагын талаар бүрэн мэдлэгтэй байх;
- (2) энэ зүйлийн (b)-гийн шаардлага хангасан байх;
- (3) техник үйлчилгээний төлөвлөлт болон удирдлагын үүрэг гүйцэтгэх хүсэлт гаргагчийн ур чадварыг тогтоох зорилгоор Даргын шаардаж болох аливаа шалгалт, эсхүл тест өгсөн байх.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан удирдах ажилтан нь:

- (1) дараах шаардлага хангасан байх үүрэгтэй:
 - (i) зохих зэрэглэлтэй, агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц, дүйцэх үнэмлэх эзэмшдэг, эсхүл эзэмшиж байсан;
 - (ii) тухайн байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа агаарын хөлөгтэй төстэй маяг болон багтаамжтай агаарын хөлгийн техник үйлчилгээний 5-аас доошгүй жилийн туршлагатай байх;
 - (iii) хяналтын албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай ба энэ туршлагыг энэ хэсгийн (1)(ii)-т шаардсан 5 жилийн туршлага хуримтлуулах үед олж авсан байж болно; эсхүл
- (2) дараах шаардлага хангасан байх үүрэгтэй:
 - (i) нисэхийн, механикийн, эсхүл цахилгааны чиглэлээр инженерийн, эсхүл түүнтэй дүйцэх мэргэжлээр төгссөн байх;
 - (ii) агаарын хөлгийн техник үйлчилгээний 5-аас доошгүй жилийн туршлагатай ба энэ туршлагыг техник үйлчилгээний хяналт, төлөвлөлт, инженерингийн боловсруулалт, эсхүл засвар үйлчилгээний ажлын орчинд олж авсан байж болно;
 - (iii) агаарын хөлгийн техник үйлчилгээний ажлыг 6 сараас доошгүй хугацаанд гардан гүйцэтгэсэн дадлага туршлагатай байх ба энэ туршлагыг энэ хэсгийн (2)(ii)-т шаардсан 5 жилийн туршлага хуримтлуулах үед олж авсан байж болно;
 - (iv) хяналтын албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх ба энэ туршлагыг энэ хэсгийн (2)(ii)-т шаардсан 5 жилийн туршлага хуримтлуулах үед олж авсан байж болно;

(c) Энэ зүйлийн (b)(1)(ii), (b)(2)(ii)-ын туршлагын шаардлагыг ИНД-141, эсхүл ИНД-147-гийн дагуу олгосон сургалтын байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд зохион байгуулсан, Даргын хүлээн зөвшөөрөхүйц зааварчилгаа өгөх сургалтын курст амжилттай хамрагдсанаар хангаж болно.

А.3.2. ИНД-125-ын үйл ажиллагаа

(а) ИНД-125-ын дагуу арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа байгууллагын техник үйлчилгээний удирдлага болон төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан нь дараах шаардлага хангасан байх үүрэгтэй:

- (1) тухайн байгууллагын Ерөнхий зааврын техник үйлчилгээнд хамааралтай хэсэг болон ИНД-125-ын техник үйлчилгээний холбогдох шаардлагын талаар бүрэн мэдлэгтэй байх;
- (2) энэ зүйлийн (b)-гийн шаардлага хангасан байх;
- (3) техник үйлчилгээний төлөвлөлт болон удирдлагын үүрэг гүйцэтгэх хүсэлт гаргагчийн ур чадварыг тогтоох зорилгоор Даргын шаардаж болох шалгалт, эсхүл тест өгсөн байх.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан удирдах ажилтан нь:

- (1) Хавсралт А.3.1-ийн шаардлага хангасан байх үүрэгтэй; эсхүл
- (2) дараах шаардлага хангасан байх үүрэгтэй:
 - (i) Хууль болон ИНД-66-гийн дагуу олгосон зохих зэрэглэлтэй, агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц, дүйцэх үнэмлэх эзэмшдэг, эсхүл эзэмшиж байсан байх;
 - (ii) тухайн байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа агаарын хөлөгтэй төстэй маяг болон багтаамжтай агаарын хөлгийн техник үйлчилгээний 3-аас доошгүй жилийн туршлагатай байх;
 - (iii) агаарын хөлгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх ажлын 1-ээс доошгүй жилийн туршлагатай байх ба тухайн туршлагыг энэ хэсгийн (ii)-т шаардсан 3 жилийн туршлага хуримтлуулах үед олж авсан байж болно; эсхүл,
- (3) тухайн байгууллагын үйл ажиллагаанд ашигладаг агаарын хөлөгтэй төстэй маяг болон багтаамжтай агаарын хөлгийн техник үйлчилгээний хяналт, удирдлага болон НТЧ-ын хадгалалтыг хариуцан ажилласан 5-аас доошгүй жилийн туршлагыг багтаасан, Даргын хүлээн зөвшөөрөхүйц туршлагатай байх үүрэгтэй.

(c) Энэ зүйлийн (b)(2)(ii)-т заасан туршлагын шаардлагыг ИНД-141, эсхүл ИНД-147-гийн дагуу олгосон сургалтын байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд зохион байгуулсан, Даргын хүлээн зөвшөөрөхүйц зааварчилгаа өгөх сургалтын курст амжилттай хамрагдсанаар орлох өөр хэлбэрээр хангаж болно.

А.4. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан

ИНД-121, 125, эсхүл 135-ын үйл ажиллагаа	
Ур чадвар	Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны холбогдох ур чадвараа харуулсан байх. Холбогдох ИНД, аюулгүй байдлын удирдлагын шаардлагын талаар ажилласан мэдлэгтэй байх.
Туршлага	Аюулгүй байдлын тогтолцооны удирдлага болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой суурь мэргэжил болон туршлагатай байх.

А.5. Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан

	ИНД-121-ийн үйл ажиллагаа	ИНД-125/135-ын үйл ажиллагаа
Шаардлагатай баримт бичиг	Чанар баталгаажуулалт, эсхүл түүнтэй дүйцэх мэргэшлийн гэрчилгээтэй байх; эсхүл ↓	Чанар баталгаажуулалт, эсхүл түүнтэй дүйцэх мэргэшлийн гэрчилгээтэй байх; эсхүл ↓
	5 жил, нисэхийн салбарт чанар баталгаажуулалтын удирдлагын чиглэлээр ажилласан туршлагатай байх;	5 жил, нисэхийн салбарт чанар баталгаажуулалтын удирдлагын чиглэлээр ажилласан туршлагатай байх;
Туршлага	5 жил, нислэгийн үйл ажиллагаа, эсхүл техник үйлчилгээний суурь мэргэжлээрээ ажилласан нисэхийн туршлагатай байх;	5 жил, нислэгийн үйл ажиллагаа, эсхүл техник үйлчилгээний суурь мэргэжлээрээ ажилласан нисэхийн туршлагатай байх;

Хэрэв тухайн этгээд нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц чанар баталгаажуулалтын удирдлагын дүйцэх туршлагатай бол түүнийг удирдах ажилтны албан тушаалын мэргэшлийн шаардлага хангасан гэж үнэлгээ хийж болно.

Хавсралт В - Ерөнхий зориулалтын АТ-ийн гэрчилгээ эзэмшигчийн удирдах ажилтны мэргэшил болон туршлага

Энэ Хавсралт нь 119.101(b)(1)(i), (ii), (iii) болон (iv)-ийн дагуу үүрэг хариуцлага хүлээх удирдах ажилтны мэргэшил болон туршлагын шаардлагыг тогтооно.

В.1. Нислэг хариуцсан удирдах ажилтан

ИНД-135-ын үйл ажиллагаа		
	3-аас олон агаарын хөлөгтэй, эсхүл 2-оос олон баазтай	4-өөс цөөн агаарын хөлөгтэй эсхүл 3-аас цөөн баазтай
Шаардлагатай баримт бичиг	Хэрэглэлийн зэрэглэлтэй коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй (CPL) байх, хэрэв үйл ажиллагаанд IFR багтдаг бол;	Хэрэглэлийн зэрэглэлтэй коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй (CPL) байх, хэрэв үйл ажиллагаанд IFR багтдаг бол;
Хөлгийн даргын туршлага	3 жил, ИНД-135-ын дагуух үйл ажиллагаанд хөлгийн даргаар ниссэн байх ба, 750 нислэгийн цаг, тухайн ашиглах ижил категорийн агаарын хөлгөөр арилжааны нислэгийн үйл ажиллагаанд, Даргын хүлээн зөвшөөрөхүйц ижил, эсхүл төстэй төрлийн арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэсэн туршлагатай байх ба; 75 цаг, бодит, эсхүл дуураймал хэрэглэлийн цагийн туршлагатай байх, хэрэв үйл ажиллагаанд IFR багтдаг бол; эсхүл ↓	500 нислэгийн цаг, тухайн ашиглах ижил категорийн агаарын хөлгөөр арилжааны нислэгийн үйл ажиллагаанд, Даргын хүлээн зөвшөөрөхүйц ижил, эсхүл төстэй төрлийн арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэсэн туршлагатай байх ба; 75 цаг, бодит, эсхүл дуураймал хэрэглэлийн цагийн туршлагатай байх, хэрэв үйл ажиллагаанд IFR багтдаг бол; эсхүл ↓
Удирдах ажлын туршлага	3 жил, Даргын хүлээн зөвшөөрөхүйц төрлийн арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэсэн туршлагыг багтаасан, нислэгийн үйл ажиллагааны хяналтын үүрэг гүйцэтгэсэн туршлагатай байх	2 жил, Даргын хүлээн зөвшөөрөхүйц төрлийн арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэсэн туршлагыг багтаасан, нислэгийн үйл ажиллагааны хяналтын үүрэг гүйцэтгэсэн туршлагатай байх

Дээр заагдсан удирдах ажилтны туршлагын шаардлагад үнэлгээ хийхдээ Дарга дараах туршлагыг нь тооцож болно:

- (a) хөлгийн дарга байх шаардлагатай мэргэшсэн удирдах ажилтны хувьд, Дарга цэргийн нисэхийн үйл ажиллагааг багтаасан ижил төрлийн арилжааны нислэгийн үйл ажиллагааны, эсхүл төстэй үйл ажиллагааны орчин, төхөөрөмжийн төрөл болон агаарын хөлгийн конфигурацитай, төстэй төрлийн арилжааны нислэгийн үйл ажиллагааны туршлагыг тооцож болно;
- (b) удирдан зохион байгуулах туршлагатай байх шаардлагатай мэргэшсэн удирдах ажилтны хувьд, Дарга арилжааны нислэгийн үйл ажиллагааны, эсхүл цэргийн нисэхийн ижил төстэй тээврийн үйл ажиллагаанд ажилласан нислэгийн үйл ажиллагааны хяналтын туршлага, эсхүл төстэй туршлагыг тооцож болно.

В.2. Багийн гишүүдийн сургалт болон ур чадварын үнэлгээ хариуцсан удирдах ажилтан

ИНД-135-ын үйл ажиллагаа		
	3-аас олон агаарын хөлөгтэй болон/эсхүл 2-оос олон баазтай	4-өөс цөөн агаарын хөлөгтэй болон/эсхүл 3-аас цөөн баазтай
Шаардлагатай баримт бичиг	Хэрэглэлийн зэрэглэлтэй коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй (CPL) байх, хэрэв үйл ажиллагаанд IFR багтдаг бол;	
Хүчинтэй байдал	Үйл ажиллагаа эрхлэгчийн агаарын хөлгийн нэг маяг дээр хөлгийн даргын үүрэг гүйцэтгэдэг байх	
Туршлага	3 жил, 135-ын үйл ажиллагаанд хөлгийн даргаар ниссэн туршлагатай байх ба 2 жил, нислэгийн шалгалт авсан ба сургалт зохион байгуулсан туршлагатай байх	-

В.3. Техник үйлчилгээний удирдлага болон төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан

(a) ИНД-135-ын дагуу арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа байгууллагын техник үйлчилгээний удирдлага болон төлөвлөлт хариуцсан удирдах ажилтан нь дараах шаардлага хангасан байх үүрэгтэй:

- (1) байгууллагын Ерөнхий зааврын техник үйлчилгээнд хамааралтай хэсэг болон ИНД-135-ын техник үйлчилгээний холбоотой шаардлагын талаар бүрэн мэдлэгтэй байх;
- (2) энэ зүйлийн (b)-гийн шаардлага хангасан байх;
- (3) техник үйлчилгээний төлөвлөлт болон удирдлагын үүрэг гүйцэтгэх хүсэлт гаргагчийн ур чадварыг тогтоох зорилгоор Даргын шаардаж болох шалгалт, эсхүл тест өгсөн байх.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан удирдах ажилтан нь дараах шаардлага хангасан байх үүрэгтэй:

- (1) Хавсралт А.3.1-ийн шаардлага; эсхүл
- (2) Хавсралт А.3.2-ын шаардлага; эсхүл
- (3) Үйл ажиллагааны тодорхойлолтод нь нийт гурав, эсхүл түүнээс цөөн агаарын хөлөг заагдсан бөгөөд хоёр, эсхүл түүнээс цөөн баазаас арилжааны нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхээр төлөвлөж байгаа, эсхүл гүйцэтгэж байгаа байгууллагын хувьд, тухайн агаарын хөлөг нь нислэгт тэнцэх нөхцөлд хадгалагдаж байгаа ба түүний техник үйлчилгээний хөтөлбөрт шаардсан техник үйлчилгээг зохих ёсоор хийдэг болохыг бататгах чадвартай байх зорилгоор техник үйлчилгээний хангалттай мэдлэгтэй байх.

(c) Энэ зүйлийн (b)(3)-ын туршлагын шаардлагыг, ИНД-141, эсхүл ИНД-147-гийн дагуу олгосон сургалтын байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд гүйцэтгэсэн, Даргын хүлээн зөвшөөрөхүйц зааварчилгаа өгөх сургалтын курст амжилттай хамрагдсанаар хангаж болно.

В.4. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан

ИНД-135-ын үйл ажиллагаа	
Ур чадвар	Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой ур чадвараа харуулсан байх. Холбогдох ИНД, аюулгүй байдлын удирдлагын шаардлагын талаар ажилласан мэдлэгтэй байх.
Туршлага	Аюулгүй байдлын тогтолцооны удирдлага болон байгууллагын ажиллагаатай холбоотой суурь мэргэжил, туршлагатай байх.

В.5. Байгууллагын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтан

ИНД-135-ын үйл ажиллагаа		
	3-аас олон агаарын хөлөгтэй болон/эсхүл 2-оос олон баазтай	4-өөс цөөн агаарын хөлөгтэй болон/эсхүл 3-аас цөөн баазтай
Шаардлагатай баримт бичиг	Чанар баталгаажуулалт, эсхүл түүнтэй дүйцэх мэргэшлийн гэрчилгээтэй байх эсхүл ↓	Чанар баталгаажуулалт, эсхүл аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ерөнхий мэдлэг болон ойлголттой байх
	Чанар баталгаажуулалт, эсхүл аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ерөнхий мэдлэг болон ойлголттой байх эсхүл ↓	
	2 жил, нисэхийн салбарт аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны чиглэлээр ажилласан туршлагатай байх;	
Туршлага	3 жил, нислэгийн үйл ажиллагаа, эсхүл техник үйлчилгээний суурь мэргэжлээрээ ажилласан нисэхийн туршлагатай байх;	

Хэрэв тухайн этгээд нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц чанар баталгаажуулалтын удирдлагын дүйцэх туршлагатай бол түүнийг удирдах ажилтны албан тушаалын мэргэшлийн шаардлага хангасан гэж үнэлгээ хийж болно.

--oOo--